

“ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС” ХК

2021 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр

№ТУЗТ 04/2021

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Хаалттай хүрээнд өрийн
хэрэгсэл гаргах тухай

Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.5, 76.1.6, 76.1.16, 76.1.18 дэх хэсэг, 76.2 дахь хэсэг, 87 дугаар зүйлийн 87.1, 87.2 дах хэсэг, 88 дугаар зүйлийн 88.1 дэх хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх хэсэг, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэг, “Эрдэнэс сольюшинс” ХК (“Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.10.7, 9.10.14 дэх хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн ээлжит бус хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компани 18 сарын хугацаатай жилийн 20 хүртэлх хувийн хүүтэй, хугацааны эцэст эсхүл хагас жилээр хүүг, үндсэн төлбөрийг хугацааны эцэст төлөх нөхцөлтэй нэг бүр нь 100,000 /нэг зуун мянга/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 5,000 /таван мянга/ ширхэг өрийн хэрэгслийг хаалттай хүрээнд хөрөнгө оруулагчдад санал болгон гаргахыг компанийн Гүйцэтгэх захирал /Ц.Хүдэрмөнх/-д зөвшөөрсүгэй.
2. Хаалттай хүрээнд санал болгон гаргаж өрийн хэрэгслийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9.4 дэх хэсэгт заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлэхтэй холбоотой баримт бичгийг бүрдүүлж, бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал /Ц.Хүдэрмөнх/-д даалгасугай.
3. Хаалттай хүрээнд санал болгон гаргаж буй өрийн хэрэгслийг хөрөнгө оруулагчдад танилцуулж, худалдахтай холбоотой үйлчилгээг үзүүлэх андеррайтерийн компанийг сонгож, энэхүү тогтоолын 1-д заасан нөхцөлөөр гэрээ байгуулан ажиллахыг Гүйцэтгэх захирал /Ц.Хүдэрмөнх/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



/Т.ЗОЛБОО/